



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 51

Есөнбулаг сум

Иргэний зөвлөлийг татан  
буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 76 дугаар тогтоол, 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар тогтоол, 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 92 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгож, "Иргэний зөвлөл"-ийг татан буулгасугай.

2. Холбогдох хууль журмын хүрээнд "Иргэний зөвлөл"-ийг шинэчлэн байгуулахыг аймгийн ИТХ-ын дарга (Л.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА

*Л. Батжаргал*

Л.БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 50

Есөнбулаг сум

Нутгийн удирдлагын байгууллагын улс төрийн  
албан тушаалтны ерөнхий бүтэц, ангилал,  
зэрэглэл зарим орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Нутгийн удирдлагын байгууллагын улс төрийн албан тушаалтны ерөнхий бүтцийг нэгдүгээр хавсралтаар, орон тооны зөвлөх, Засаг даргын орлогч, хэвлэлийн төлөөлөгч, туслахын ангилал зэрэглэл, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулж 2019 оны батлагдсан төсөвт зохицуулалт хийж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.


ДАРГА  Л.БАТЖАРГАЛ




Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын  
2019 оны 07-р сарын 08-ны өдрийн 50-р  
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН УЛС ТӨРИЙН  
АЛБАН ТУШААЛТНЫ БҮТЭЦ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын  
2019 оны 07-р сарын 08-ны өдрийн 50-р  
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН  
ОРОН ТООНЫ ЗӨВЛӨХ, ОРЛОГЧ, ТУСЛАХ, ХЭВЛЭЛИЙНТӨЛӨӨЛӨГЧИЙН  
АНГИЛАЛ ЗЭРЭГЛЭЛ, ОРОН ТОО

| №                    | Албан тушаал   | Ангилал,<br>зэрэглэл | Орон тоо |
|----------------------|--|----------------------|----------|
| Аймгийн ИТХ-ын дарга |  |                      |          |
| 1.                   | Аймгийн ИТХ-ын даргын орон тооны зөвлөх  | УТ                   | 1        |
| Аймгийн Засаг дарга  |  |                      |          |
| 1.                   | Аймгийн Засаг даргын Эдийн засаг, хөрөнгө, оруулалтын асуудал хариуцсан зөвлөх | УТ                   | 1        |
| 2.                   | Хөгжлийн бодлого хариуцсан орлогч  | УТ                   | 1        |
| 3.                   | Нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч                                     | УТ                   | 1        |
| 4.                   | Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч   | ТҮ                   | 2        |
| 5.                   | Засаг даргын туслах  | ТҮ                   | 1        |



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 51

Есөнбулаг сум

Иргэний зөвлөлийг татан  
буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 76 дугаар тогтоол, 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар тогтоол, 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 92 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгож, "Иргэний зөвлөл"-ийг татан буулгасугай.

2. Холбогдох хууль журмын хүрээнд "Иргэний зөвлөл"-ийг шинэчлэн байгуулахыг аймгийн ИТХ-ын дарга (Л.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Л.БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 49

Есөнбулаг сум

Бүсчилсэн хөгжлийн бодлогод  
санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүсчилсэн хөгжлийн бодлогод оруулах саналыг эрэмбэлэн Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 48

Есөнбулаг сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж" заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, тэмцэх арга хэмжээний үйлчилгээний хөлс, зардлыг олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д үүрэг болгосугай.

3. Уг журам батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА *А.Батжаргал* Л.БАТЖАРГАЛ





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 47

Есөнбулаг сум

Илтгэл, илтгэгч батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын есдүгээр хуралдаанаар хэлэлцүүлэх илтгэл, илтгэгчийг дор дурдсанаар баталсугай.

1. Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тухай

Илтгэгч нь: ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Жаргалсайхан

2. Аймгийн 2018 оны төсвийн шилжих үлдэгдэл зарцуулах тухай

Илтгэгч нь: ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Жаргалсайхан

3. Аймгийн 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг даргын орлогч Ж.Ганбат

4. Газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай

Илтгэгч нь: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д.Батмагнай

5. Сумын ИТХ-ын Төлөөлөгчдөд урамшуулал олгох журам батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Амарзаяа

ДАРГА  Д.БАТЖАРГАЛ

